

Хурдан байшин дуюу  
Олондоо тусгай  
Ойн автобус

Т.Талсан



**Т. ГАЛСАН**

**“ХУРДАН БАЙШИН БУЮУ ОЛОНДОО ТУСТАЙ ОЙН  
АВТОБУС” ХЭМЭЭХ ҮЛГЭР**

*(Сургуулийн дунд насныханд)*

“БНМАУ. Ардын боловсролын яамны Сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн  
редакцын газар” Улаанбаатар хотноо 1986 онд эрхлэн хэвлүүлсэн  
“ДЭГДЭЭХЭЙ НАСНЫ ҮЛГЭРҮҮД”

НОМООС

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар Цагаан бамбарууш хэвлэлийн  
газарт 2021 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: [www.e-nom.mn](http://www.e-nom.mn)

-

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.  
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу  
орно уу.

**Б**  
БОЛОР ДУРАН 2.0  
АЛДАА ШАЛГУУР

**“БОЛОР ДУРАН”  
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ  
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР

## ХУРДАН БАЙШИН БУЮУ ОЛОНДОО ТУСТАЙ ОЙН АВТОБУС ХЭМЭЭХ ҮЛГЭР

СЭРЭЭРЭЙ, СЭРЭЭРЭЙ! гэж  
Тахиа донгодох нь яруу!  
ШИНЭ ӨДӨР...ШИНЭ ӨДӨР! гэж  
Нахиа сэрчигнэх нь яруу!

Хөөрөн нисэх гэж  
Жигүүртнүүд яарах нь зоримог.  
Хөөрхөн дэгдээхэй  
Нүд нь анилдаад нойрмог!

Өвсний шүүдэрт  
Дөл бадрах нь сонин!  
Өргөн тэнгист  
Гал бадамлах нь содон!

Хөгжөөн хөдөлгөөнт  
Энэ үе хэдийд вэ?  
Хөвч ой  
Нойрноосоо хэзээ сэрдэг вэ?<sup>1</sup>

Илчтэй нар  
Бултайн шагайдаг зүүнээс  
Эвэртэй сар  
Бултаж нуугддаг баруунаас

Тожир бүжир  
Тожир бүжир гүйлдэн  
Толгой дохиж  
Малгай өргөж мэндлэн

Хөвчийн амьтад  
Шүглийн дуугүй уралдана.  
Хөлийн хурдаар  
Шүүгчийн дохиогүй жирийлдэнэ.

— БУШУУЛ, БУШУУЛ! гэж  
Ан гөрөөс бухимдана.  
Бугуйн цагаа  
Ахин дахин хялалзана.

Амандаа угжтай  
Ангаахай ч бөөн яарал!  
Дэвтрээ сугавчилсан  
Дэгдээхэй ч бүр яарал!

Ямар юмандаа  
Яараад тэр вэ?  
Яагаад тэд  
Цагийн зүүтэй уралдана вэ?<sup>2</sup>

Амарч суух  
Түшлэг бат сандалтай  
Аадар хураас  
Түр халхлах дээвэртэй

Эрээн шон дээрээ  
Цагийн хуваарь бичээстэй  
Индүүдэж тэгшилсэн  
Цардмал өргөн дэвсэгтэй

Сэрүүн сэхээвч рүү  
Ойн амьтад уралдав.  
Шил шилээ  
Ширтэн харж зогсоцгоов.

Унаа хүлээдэг  
Энэ газрыг нэрлэ!  
Уртаашаа ганц  
Эгнэдгийн учрыг тайлбарла!<sup>3</sup>

Төмөр дээвэртэй  
Дулаан том байшингаас  
Дөрвөн дугуйтай  
Улаан байшин давхиж ирлээ.

«Хурдан орцгоо!  
Тавтай морилцгоо!» гэж урина бололтой  
Гурван хаалга нь  
Татуур оньсоор уралдан онгойлоо

Дулаан байшингаас ирсэн  
Улаан байшинг юу гэдэг вэ?  
Явдаг энэ байшин  
Ямар ач тустай вэ?<sup>4</sup>

Шил шилээ хараад  
Ан амьтад урагшилна.  
Шил толин автобусанд  
Аятайхан цувраад орно!

Харааны шил хагалдаггүй  
Хавирга сүврэг хугалдаггүй  
Хаалганы бариул булгалдаггүй  
Хараал ерөөл урсгадаггүй

Ирсэн дарааллаа эвддэггүй  
Ив эе дайрдаггүй  
Эмх горимоо алддаггүй  
Ийм журам ямар вэ?<sup>5</sup>

Хөвчийн аварга  
Хүчдэн зүтгэх нь мангар.  
Хөөрхөн ботгоны  
Хөл дээр гишгэх нь айхавтар

Дэлдэн туулайг  
Дэвсчих шахах нь болгоомжгүй.  
Хуцын эврийг  
Хугалчих дөхөх нь болчимгүй!

Ухаан багатай, том биетэн  
Уур ихтэй, соёл багатай  
Энэ амьтны нэрийг хэл!

Эзэрхий зан ямрыг шүүмжил!<sup>6</sup>

Давхиж яваа байшин дотор  
Дадамгай нэг саальчин явна.  
Булигаараар урласан хувин руу  
Бутархай мөнгө сааж сууна.

Орлого ч ихтэй, үг ч олонтой  
Овсгоот саальчны нэр нь хэн бэ?  
Хөлөөрөө явдаг ан амьтдыг  
Голоороо яв гэлээ. Зөв үү?<sup>7</sup>

Тойрог зууван зам  
Элэгдтэл эрээлжилтэл давхивч  
Толгой нь ердөө эргэдэггүй  
Нүд нь огт эрээлжилдэггүй

Хөндлөн тийшээ тольдовч  
Хүзүү нь гилжгий болоогүй  
Өчнөөн жил давхихдаа  
Үнэмлэхээ цоолуулж үзээгүй

Золбоо төгс аянчны  
Хийморьтой мэргэжил юу вэ?  
Зорчигч олон түүнийг  
Хэн гэж дууддаг вэ?<sup>8</sup>

Сул дорой нэгийгээ  
Сугадаж түшиж оруулаад  
Зөөлөвчтэй түшлэгтэй сандалд  
Зөөлхөн хүргэж суулгаад

Аргаль янгир  
Буга согоо урагшлав гэнэ.  
Автобусныхаа зардлыг  
Бушуу бушуухан төлөв гэнэ.

Амьтны биед шүргэчих вий гээд  
Араатны гижиг хүргэчих вий гээд

Аргай даргай эврээн  
Ар нуруундаа наав гэнэ.

— Ээ гялай, ээ гялай  
Азын сугалаа таарчээ!  
Их удахгүй би  
Эрхэст сансарт нисэх нь ээ! гэж

Наргин алиалсаар урагшлав гэнэ  
Насныхаа эрэмбээр суув гэнэ.  
Эв найр, инээд наргиантай  
Ийм зочдыг дуурайвал ямар вэ?<sup>9</sup>

Буудаг ёстой  
Урд хаалгыг зад нээлээ.  
Булхайч саарал  
Уухилан аахилан орж ирлээ.  
Шинэхэн тасалбар

Шалан дээр хэвтээг харлаа  
Сэмхэн тонгойж  
Шалавхан аваад туулай шиг хярлаа.  
Улаач ирээд

Бээлийтэй алгаа тослоо  
Уранхай тасалбараа  
Булхайч саарал харууллаа.

Аль эрт  
Авчихсаан! гэж мэлзлээ.  
Үнэнч Үнэг  
Үзсэн дээ! гэж мэтгэлээ.

Арван зуут  
Түрийвч дотор нь багсайвч  
Автобусныхаа хөлсийг  
Төлөлгүй гөлөлзсөөр буулаа.

Буух хаалгаар  
Огцом дайрч ордог  
Будилаан хутган  
Орох хаалгаар гардаг

Булхайч саарал  
Ямар гээч амьтан бэ?  
Будилаан тарьж явах  
Яршигтай, юу, таатай юу?<sup>10</sup>

Оготнын дэргэд бол  
Мазаалай шиг томхон  
Оонын дэргэд бол  
Малгай шиг жаахан

Сагсгар сүүл нь  
Биеэсээ урт амьтан  
Сандлын ирмэгт суугаад  
Самар цөмж явна.

Самрынхаа ясыг  
Атган дотроо хураалгүй  
Шалан дээгүүр  
Асгаж, унагаж сууна.

Автобус гэдэг унаа  
Зоогийн газар мөн үү?  
Аян замд зорчингоо  
Хоол идэх нь зөв үү?<sup>11</sup>

Илүү сандал байхаар нь  
Ил очоод суулаа.  
Хажуу талд нь тэгтэл  
Хандгай ирээд зогслоо.

— Энд суу, та гээд  
Ил босох нь магтмаар.  
— Их баярлалаа, хүү минь! гээд  
Хандгай суух нь бахадмаар.

Өөрийнхөө тугалтай Илийг  
Зүйрлэн хайрлах нь уярмаар.  
Өвөр дээрээ суулгаад  
Чихэр өгөх нь дэндмээр.

— Баярлалаа, зүгээр! гэж  
Ил хэлэх нь гайхмаар.  
Бал бурамтай чихэр  
Идэхээс татгалзах нь гомдмоор!

— Зүгээр.., гэж Ил  
Ямар учраас хэлээ вэ?  
Зөөлөн чихрийг тэр  
Ягаад авч идсэнгүй вэ?<sup>12</sup>

Бор баавгайн  
Борви доогуур мөлхөн  
Босоо хандгайн  
Суга доогуур хөлхөн

Улаан хантаазат амьтан  
Бултан бултан сүлжив гэнэ  
Урд талд очоод  
Буруу харж суув гэнэ.

Өдрийн сонин дэлгээд  
Ар талд нь нуугдав гэнэ.  
Өтгөн сахалт янгирыг  
Ажаагүй, үзээгүй, царайлав гэнэ.

Амиа, хувиа хичээсэн  
Аргат улаан юу вэ?  
Аав шигээ ахмадыг хүндлэхгүй  
Ингэж явах ямар вэ?<sup>13</sup>

Автобусны улаачид төлөөрэй! гэж  
Аавынхаа өгсөн мөнгөөр

Амтат улаан лууван  
Арвыг аваад мэрчихсэн

Дэлдэн БОР, автобусны хажуугаар  
Дэгдэн дэгдэн амьсгаадаж явна.  
Дэвтэр ном дүүрэн цүнхээ  
Тэвэрсээр сургуульдаа хүрч явна.

Идэмхий ч гэсэн үнэнч шударга  
Энэ амьтан хэний хэн бэ?  
Эртхэн гараад ой дундуур  
Ингэж гүйвэл яасан юм бэ?<sup>14</sup>

Цаг мөчтэй уралдан  
Цардмал замаар уухилан  
Уужуу зайтай дан байшин  
Уралдааны морь шиг давхисаар л...

Аварга биет зааныг ч  
Атгын чинээ зарааг ч  
Үнэг гүйцдэг хуланг ч  
Үсэрч дэвхэрдэг мэлхийг ч

Ажлаас нь, хичээлээс нь  
Нэг ч мөч хождуулдаггүй  
Автобусны жолоочид хэлэх  
Нийтийн талархал юу вэ?<sup>15</sup>

Үүр үүрэндээ харих гэж  
Ан амьтан яаруу.  
Өндөг ангаахайдаа аялах  
Шувуудын бүүвэй яруу!

Тэнгэрт түсрэглэж түгсэн  
Од мичид найруу.  
Дэлхий даяханд самрах  
Сарны туяа цайруу.

Бамбаруушаа балаар угжих гэж  
Баавгайн мэрийх нь шавдуу.  
Бамбараа эртхэн унтуулах гэж  
Бар гуайн үлгэр ярих намдуу.

Илчтэй нар ядраад  
Унтаж амарсан шөнөөр ч  
Эвэртэй сар оронд нь  
Ургаж гийсэн цагаар ч

Шөнийн зорчигчдыг  
Орон гэрт нь хүргэх гэж  
Сүүлчийн автобус  
Ойгоор хурдлах нь махруу!

Төмөр дээвэртэй  
Дулаан байшиндаа цуглах  
Дөрвөн дугуйтай  
Улаан байшингийн ач агуу!

Хув, ган хэлхэж  
Хурдан унаа хийгээд  
Өргөн олон түмэндээ  
Үйлчилж явах ямар вэ?<sup>16</sup>

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.  
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу  
орно уу.

**5**  
БОЛОР ДУРАН 2.0  
МЭДЭЭЛЭЛЭГ

**“БОЛОР ДУРАН”  
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ  
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үеийн сантай.
- ✓ Алдаатай үеийг илрүүлж, зөв үеийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үеийн сан үүсгэх боломжтой.

## Өглөгийн эзний сонорт



Та манай номын санд хандив өргөж болно.

### Таны хандивласан мөнгө:

- Хэвлэгдсэн номыг цахим хэлбэрт оруулах
- Цахимд оруулсан номыг ариутган шүүх
- Цахим технологийн тоног төхөөрөмж авах
- Цахим номын санг өргөжүүлэх
- Цахим номын сангийн чиглэлээр судалгаа хийж, сурч байгаа оюутан судлаачийг дэмжихэд зарцуулагдана.

Хандив өргөх данс "Хаан банк" 5027 8982 35 (төгрөг) ЦОГТ ОХИН ТЭНГЭР САН

Qpay

**1986 онд БНМАУ-ын Ардын боловсролын яамны Сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар эрхлэн хэвлүүлсэн “ДЭГДЭЭХЭЙ НАСНЫ ҮЛГЭРҮҮД” номын Гарчиг :**

“Цэнхэр эргүүлийнхэн буюу анхны гавьяа” хэмээх үлгэр

“Зөвлөлт хүн буюу улаан туг” хэмээх үлгэр

“Үгэн-эм” хэмээх үлгэр

“Хурдан байшин буюу олондоо тустай ойн автобус” хэмээх үлгэр

“Зуны амралт буюу явдаг дэлгүүр” хэмээх үлгэр

## **1986 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл :**

*Т. ГАЛСАН*

### ***ДЭГДЭЭХЭЙ НАСНЫ ҮЛГЭРҮҮД***

*(Сургуулийн дунд насныханд)*

Редактор *С. Надмид*

*БНМАУ*

*Ардын боловсролын яамны*

*Сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар*

*Улаанбаатар 1986 он*

*Хэвлэлийн редактор Ц. Сүхбаатар*

*Уран сайхны редактор П. Оюунцэцэг*

*Зураач Б. Төмөрбат*

*Техник редактор Р. Оюун*

*Хянагч Д. Цэнд-Аюуш, Д. Шүр*

*А № 96263*

*За № 186*

*ХГ № 40/86*

*Өрөлтөд 1986 оны 6 сарын 2-нд*

*Хэвлэлтэд 1986 оны 7 сарын 5-нд*

*Цаасны хэмжээ 84x108/32*

*Х. х. 3*

*ХНХ 5.04*

*Хэвлэсэн тоо 6000*

*Үнэ 2 тө.*

*Улаанбаатар 46*

*АБЯ-ны сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцын газар Их сургуулийн  
гудамж 3*

*Д. Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн комбинатад хэвлэв.*

*Д. Сүхбаатарын талбай 2*

Заметки

[←1]

(Өглөөгүүр Үүрээр)

[←2]

(Ажилдаа очих гээд  
Автобусандаа орох гээд)

[←3]

(Энэ бол

Автобусны буудал

Эмх горим

Аль ч газар чухал)

[←4]

(Автобус гэдэг  
Ажилд хүргэдэг)

[←5]  
(Зүйтэй!  
Зөв!)

[←6]

(Түүний нэр Баавгай !  
Түрэмгий зан муухай !)

[←7]

(Автобусны үйлчлэгчийг УЛААН гэдэг  
Андуу яривал доог болдог)

[←8]  
(Жолооч!)

[←9]

(Ярих юмгүй зөв!  
Яг зөв!)

[←10]

(МУУХАЙ- БООХОЙ)

[←11]

— Бор хэрэм (Болохгүй- буруу!)

[←12]

(Сандал өгчхөөд  
Сайрхах нь муухай  
Шагнал горьдвол  
Бүр ч муухай!)

[←13]

(Аргат улаан нь үнэг гуай  
Амиа хичээх нь үнэхээр муухай)

[←14]

(Туулай бүжин тун ч сайхан!)

[←15]

(Их баярлалаа)

[←16]

(Магтмаар сайхан  
Бахадмаар гоёхон!)